



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/49/НА-СТА-ТӨААТҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх  
аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Аудитор: С.Алтанхуяг  
Утас: 261628 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Өлзийт экаунт аудит”  
ХХК-ийн захирал: Ц.Бямбажав  
Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.com

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Монголын хөрөнгийн бирж ТӨХК, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл. ....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	21
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	22
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	23



**Товчилсон үгийн жагсаалт**

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ”  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Х.АЛТАЙ ТАНАА

2023.03.21 № 07/616  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь нийт хувьцааныхаа 34 хувийг олон нийтэд санал болгосон бөгөөд 2022 оны 12 сарын 26-наас 12 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хувьцаа худалдах санал хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ын хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах шийдвэрийн хүрээнд ТУЗ-ийн 2022 оны 19 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 505 дугаар хөрөнгийг дахин үнэлэх тогтоолын дагуу барилга, байгууламжийг 4,925.0 сая төгрөг, тээврийн хэрэгслийг 7.3 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийг 529.6 сая төгрөг, тавилга эд хогшил 118.7 сая төгрөг, биет бус хөрөнгө болон газрыг 17,895.5 сая төгрөг нийт 23,476.3 сая төгрөгөөр үнэлж тайлант онд тайлагнасан байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ





## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,729,363,635.92	1,731,709,823.19
1.1.2	Дансны авлага	97,240,920.31	504,659,308.86
1.1.3	Татвар, НД-н шимтгэлийн авлага	18,336.58	822,948.07
1.1.4	Бараа материал	26,570,837.69	33,650,495.17
1.1.5	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	7,666,370.89	12,775,744.36
1.1.6	Бусад эргэлтийн хөрөнгө	13,160,000.00	13,160,000.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,874,020,101.40</b>	<b>2,296,778,319.65</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,121,771,489.56	5,536,483,495.32
1.2.2	Биет бус хөрөнгө	382,782,168.52	17,648,438,922.94
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,504,553,658.08</b>	<b>23,184,922,418.26</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,378,573,759.48</b>	<b>25,481,700,737.91</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1.1	Дансны өглөг	720,558,353.30	793,176,221.30
2.1.1.2	Татварын өглөг	206,262,926.45	190,085,198.35
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	14,247,509.45	15,396,128.31
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>941,068,789.20</b>	<b>998,657,547.96</b>
2.1.1	Хойшлогдсон татварын өр	-	990,846,139.66
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>990,846,139.66</b>
	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>941,068,789.20</b>	<b>1,989,503,687.62</b>
<b>2.2</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.2.1	Өмч: а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.2.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,362,216.67	20,021,146,332.29
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
<b>2.4</b>	<b>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</b>	<b>(19,151,772,748.41)</b>	<b>(20,105,864,784.03)</b>
	Хуримтлагдсан ашиг (өмнөх үеийн)	(22,336,322,387.40)	(20,752,093,007.67)
	Хуримтлагдсан ашиг (тайлант үеийн)	3,184,549,638.99	646,228,223.64
	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>4,437,504,970.28</b>	<b>23,492,197,050.28</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>5,378,573,759.48</b>	<b>25,481,700,737.91</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,483,078,582.38	4,241,344,850.62
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>5,501,624,362.55</b>	<b>4,241,344,850.62</b>
4	Хүүгийн орлого	19,301,917.80	-
5	Бусад орлого	18,545,780.17	27,070,762.46
6	Ерөнхий ба удирдлагын зардал	2,136,265,973.93	3,557,629,057.47
7	Бусад зардал	30,363,052.75	71,765,222.02
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	57,525.18	130,867,477.80
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,619,200.00)	(141,003.17)
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>3,352,735,578.87</b>	<b>769,747,808.20</b>
13	Орлогын татварын зардал	168,185,939.88	123,519,584.56
14	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>3,184,549,638.99</b>	<b>646,228,223.64</b>
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		
16	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>20,008,784,115.62</b>
17	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		20,008,784,115.62
18	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
19	Бусад олз (гарз)		
20	<b>Орлогын нийт дүн</b>	<b>3,184,549,638.99</b>	<b>20,655,012,339.26</b>
21	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		



**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(22,336,322,387.40)</b>	<b>1,252,955,331.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				3,184,549,638.99	<b>3,184,549,638.99</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(19,151,772,748.41)</b>	<b>4,437,504,970.28</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
<b>2021 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(19,151,772,748.41)</b>	<b>4,437,504,970.28</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,600,320,259.26)	(1,600,320,259.26)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>12,362,216.67</b>	<b>446,321,902.02</b>	<b>(20,752,093,007.67)</b>	<b>2,837,184,711.02</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				646,228,223.64	646,228,223.64
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		20,008,784,115.62			20,008,784,115.62
<b>2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>23,130,593,600.00</b>	<b>20,008,784,115.62</b>	<b>446,321,902.02</b>	<b>(20,105,864,784.03)</b>	<b>23,492,197,050.28</b>





## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,699,769,998.43</b>	<b>3,914,481,245.55</b>
1.1.1	Бараа Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,951,952,451.43	3,735,454,914.86
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,896,176.00	1,684,791.01
1.1.3	Бусад мөнгөн орлого	736,921,371.00	177,341,539.68
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,427,313,725.08</b>	<b>4,619,870,426.48</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	585,159,426.87	878,401,879.77
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	182,327,806.06	259,137,491.60
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,291,525.19	35,755,782.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	46,951,542.21	65,253,743.16
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,120,710.00	7,674,470.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	348,440,826.15	473,654,111.92
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,233,021,888.60	2,901,993,148.03
	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>2,272,456,273.35</b>	<b>(705,389,180.92)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>19,301,917.80</b>	<b>-</b>
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	19,301,917.80	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>116,984,363.64</b>	<b>423,392,511.67</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	116,984,363.64	423,392,511.67
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(97,682,445.84)</b>	<b>(423,392,511.67)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>131,127,879.87</b>
3.1.2	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		131,127,879.87
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>131,127,879.87</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,174,773,827.51</b>	<b>(997,653,812.72)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>554,589,808.41</b>	<b>2,729,363,635.92</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,729,363,635.92</b>	<b>1,731,709,823.19</b>



**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 оны Гүйцэтгэл	2022 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2
<b>А</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>5,520,926.0</b>	<b>6,033,833.0</b>	<b>4,268,416.0</b>	<b>(1,765,417.0)</b>	<b>(70.0)</b>
1	Хувьцааны арилжааны шимтгэл	2,189,894.0	2,369,874.0	1,845,985.0	(523,888.0)	(77.0)
2	Бондын арилжааны шимтгэл	955,513.0	1,024,151.0	157,520.0	(866,631.0)	(15.0)
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	402,700.0	201,350.0	27,607.0	(173,743.0)	(14.0)
4	Нүүрсний арилжааны шимтгэл				-	
5	Гишүүнчлэлийн жилийн хураамж	70,569.0	72,470.0	69,139.0	(3,331.0)	(95.0)
6	Терминал ашигласны хураамж	58,145.0	61,691.0	61,439.0	(252.0)	0.0
7	Бүртгэх үйлчилгээний орлого	799,533.0	1,596,990.0	1,357,192.0	(239,798.0)	(84.0)
8	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	253,224.0	317,932.0	381,926.0	63,994.0	120.0
9	Сургалтын орлого	13,000.0	54,000.0		(54,000.0)	(100.0)
10	Мэдээллийн үйлчилгээний орлого	136,627.0	219,279.0	185,380.0	(33,899.0)	(85.0)
11	Хүүгийн орлого	19,302.0	20,000.0		(20,000.0)	(100.0)
12	Бусад орлого	112,443.0	96,098.0	175,864.0	79,766.0	183.0
13	МИТ ашиглалтын орлого	509,974.0		6,364.0	6,364.0	0.0
<b>Б</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>2,168,248</b>	<b>4,354,385.0</b>	<b>3,629,394</b>	<b>(724,991.0)</b>	<b>(83.0)</b>
1	Ажилтнуудын цалин хөлс	692,281.0	1,105,643.0	999,499.0	(106,144.0)	(90.0)
2	НДШ-ийн зардал	92,047.0	149,699.0	126,870.0	(22,829.0)	(85.0)
3	Удирдлагын зардал	37,725	117,498.0	93,035.0	(24,463.0)	(79.0)
4	Материал, бичиг хэрэг	11,871.0	17,132.0	20,095.0	2,963.0	117.0
5	Харилцаа холбооны зардал	6,061.0	7,407.0	6,096.0	(1,311.0)	(82.0)
6	Интернэт ашиглалт	16,922.0	19,747.0	18,617.0	(1,130.0)	(94.0)
7	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	9,411.0	8,481.0	8,802.0	321.0	103.0
8	Урсгал засвар	15,511.0	50,012.0	19,995.0	(30,017.0)	(40.0)
9	Цахилгаан, дулаан, ус, хог	45,320.0	55,560.0	43,825.0	(11,735.0)	(79.0)
10	Албан томилолт	-	-	-		
11	Сургалт семинар	2,931.0	24,615.0	6,061.0	(18,554.0)	(25.0)
12	Нийгэм соёлын арга хэмжээ	23,417.0	26,836.0	18,774.0	(8,062.0)	(70.0)
13	Маркетинг, бизнес харилцааны зардал	2,991.0	100,100.0	62,880.0	(37,220.0)	(63.0)
14	Мэдээлэл технологийн зардал	10,246.0	90,082.0	27,615.0	(62,467.0)	(31.0)



Монголын хөрөнгийн бирж ТӨХК -ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

15	Бусад зардал	24,204.0	27,166.0	56,357.0	29,191.0	207.0
16	Элэгдлийн зардал	239,014.0	497,192.0	396,509.0	(100,683.0)	(80.0)
17	Зохицуулах үйлчилгээний хөлс	-	231,570.0	117,121.0	(114,449.0)	(49.0)
18	MIT ашиглалтын зардал:	938,295.0	844,191.0	1,221,204.0	377,013.0	144.0
	Үүнд: MIT - Элэгдлийн зардал	144,377.0	-	342,168.0	342,168.0	0.0
	MIT - Төслийн зардал	793,918.0	844,191.0	879,036.0	34,845.0	104.0
19	IPO хийхтэй холбоотой мэргэжлийн байгууллагын болон зөвлөх үйлчилгээний зардал	-	981,455.0	386,039.0	(595,416.0)	(39.0)
<b>В</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>3,352,678.0</b>	<b>1,679,448.0</b>	<b>639,021.0</b>	<b>(1,040,427.0)</b>	<b>(38.0)</b>
1	Үндсэн хөрөнгө данснаас хассаны /олз/ гарз	-		(141.0)	(141.0)	
2	Гадаад валютын ханшийн бодит бус цэвэр орлого	58		130,867.4	130,867.4	0.0
<b>Д</b>	<b>ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ (В+Г)</b>	<b>3,352,736.0</b>	<b>1,679,448.0</b>	<b>769,748</b>	<b>(909,700.62)</b>	<b>(46.0)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Монголын хөрөнгийн бирж ТӨХК, түүний үйл ажиллагаа

Монголын хөрөнгийн бирж ТӨХК эрхэм зорилгоо санхүүгийн зах зээл дэх хөрөнгө хуримтлалыг хямд өртөгтэйгөөр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллагын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2-т үйл ажиллагааны үндсэн чиглэлийг “Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа” гэж заасан байна.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийг үүсгэн байгуулсан.

#### 3.2 Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Их Хурлын 2022 оны өдрийн №16 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн дагуу нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх тогтоолыг баталсан.

Компаний удирдлагыг ТУЗ, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Сангийн сайд томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1-д “ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ТУЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн 16 дугаар тогтоолоор “Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-д өөрчлөлт орсныг тайлант оноос эхлэн хэрэгжүүлсэн.
- ТУЗ-ын 2022 оны 08 дугаар тогтоолоор “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар компанийн хувьцаа бүртгэх үйлчилгээний хөлс 10.0- 40.0 хувиар, компанийн бонд бүртгэх үйлчилгээний хөлс 36.0 хүртэлх хувиар бууруулж, “Арилжааны журам”-ын нэмэлт өөрчлөлтөөр анхдагч зах зээлд хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргагчийн төлөх арилжааны шимтгэлийг 100.0 хувь бууруулсан.
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ын дагуу нүүрсний арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох ажлын хүрээнд хууль зүйн зөвлөх үйлчилгээ, аудитын зөвлөх үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээний зөвлөх үйлчилгээ, андеррайтерын зөвлөх үйлчилгээг хийлгэн, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажилласан байна.



Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Хөрөнгийн дахин үнэлгээ, хойшлогдсон татварын өр төлбөр, найдваргүй авлагын нөөц зэрэг данснуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,103.1 сая төгрөгөөр буюу 4.7 дахин өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,729,363.64	1,731,709.82	(997,653.81)
Авлага	104,925.63	518,258.00	413,332.37
Бараа материал	26,570.84	33,650.50	7,079.66
Бусад эргэлтийн хөрөнгө	13,160.00	13,160.00	-
Үндсэн хөрөнгө	2,504,553.66	23,184,922.42	20,680,368.76
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,378,573.76</b>	<b>25,481,700.74</b>	<b>20,103,126.98</b>
Өр төлбөр	941,068.79	1,989,503.70	1,048,434.91
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,437,504.97	23,492,197.04	19,054,692.07
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,378,573.76</b>	<b>25,481,700.74</b>	<b>20,103,126.98</b>

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данстууд байна. Тухайлбал,



Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 997.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны эцэст ТӨБЗГ-т 1,592.2 сая төгрөгийн ноогдол ашиг төлсөнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 518.3 сая төгрөг болж, өмнөх оноос 413.3 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын сангийн авлага 450.0 сая төгрөг төлөгдөөгүй, маргаантай байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 23,184.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 20,680.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ТУЗ-ын 2022 оны 19 тоот тогтоолоор 23,476.3 сая төгрөгөөр хөрөнгийг дахин үнэлж бүртгэсэн ба шинээр худалдан авсан 423.4 сая төгрөг нийт 23,899.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 396.6 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 505 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 356.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассанаар буурчээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,989.5 сая төгрөг болж, өмнөх оноос 1,048.4 сая төгрөгөөр өссөн нь хойшлогдсон татварын өр төлбөр 990.8 сая төгрөг, Лондоны хөрөнгийн биржид төлөх лиценз ашиглалт, засвар, үйлчилгээний гадаад төлбөр 751.8 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 998.6 сая төгрөг, Татварын байгууллагад төлөх 190.1 сая төгрөгийн өрийг тайлант онд төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 23,492.2 сая төгрөг болж өссөн нь биет болон биет бус хөрөнгийг дахин үнэлж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэсэн 20,008.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бол, мөн ТӨБЗГ-т тайлант онд төвлөрүүлсэн 1,592.2 сая төгрөгийн ноогдол ашиг, өмнөх оны аудитын залруулгаар элэгдлийн зардлын залруулан бүртгэсэн 20.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу 2022 оны санхүүгийн төлөвлөгөө боловсруулан зохих байгууллагаар боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сангийн сайдын 2022 оны 99 тоот тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,033.8 сая төгрөг, нийт зардлыг 3,269.4 сая төгрөг, 2,487.8 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,057.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдахтай холбоотой зөвлөх үйлчилгээний болон мэргэжлийн үйлчилгээний зардалд 981.4 сая төгрөг, программ ашиглалтын зардал 108.1 сая төгрөг, зохицуулах үйлчилгээний хөлс 231.6 сая төгрөг нийт 1,321.1 сая төгрөгийг тус бүр нэмж тодотгосон байна.

Сангийн сайдын 2022 оны 20 дугаар тогтоолоор Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн дагуу нийт зардлыг 4,354.4 сая төгрөгөөр, татварын өмнөх ашгийг 1,679.4 сая төгрөг байхаар бууруулан тодотгон баталжээ.

Гүйцэтгэлээр 4,268.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,557.6 сая төгрөгийн зардал гарган, 769.7 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 4,268.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,765.4 сая төгрөг буюу 29.0 хувиар тасарсан нь Голомт, Төрийн банк, Хаан банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банкнуудын хувьцааг нийтэд худалдахаар төлөвлөн зорилтот түвшинд тусгасан байсан боловч нэр бүхий 3 банкны хувьцаа гаргах үйл ажиллагаа хойшилсонтой холбоотой



хувьцааны арилжааны шимтгэлийн орлого 22 хувь, үнэт цаас бүртгэх үйлчилгээний хураамжийн орлого 15 хувиар буурснаас тус бүр шалтгаалан биелээгүй байна.

Нийт зардлын гүйцэтгэл 3,557.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 724.9 сая төгрөг буюу 17.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлсний зардлыг 106.1 сая төгрөг, маркетинг, бизнес харилцааны зардлыг 37.2 сая төгрөг, зохицуулах үйлчилгээний хураамжийн зардлыг 114.4 сая төгрөг, олон нийтэд нээлттэй хувьцаа гаргахтай холбоотой мэргэжлийн байгууллагын болон зөвлөх үйлчилгээний зардлыг 357.4 сая төгрөг, нийт 615.1 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Тайлант онд цэвэр ашиг 646.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,040.4 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө 29.0 хувиар тасарсантай холбоотой.

Тайлант онд ТӨБЗГ-т ноогдол ашгийн 1,592.2 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Монголын хөрөнгийн бирж ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн үйл ажиллагааг сайжруулах бараа материал, авлага, зардал данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Ч.Эрдэнэжав, аудитор Т.Отгонцэцэг, аудиторын туслах Б.Отгонсүрэн, Д.Мандахбаяр, Б.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын захирал Ц.Бямбажав, менежер Ч.Оюун нар тус тус хэрэгжүүлсэн.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг УАГ-т 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 01/111 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 5,520.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 57.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 49.2 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, материал бичиг хэргийн зардлыг 0.6 сая төгрөг, харилцаа холбооны зардлыг 0.4 сая төгрөг, сэлбэг, шатахууны зардал 2.6 сая төгрөг, албан томилолтын зардлыг 62.4 сая төгрөг, маркетинг, бизнес харилцааны зардлыг 119.9 сая төгрөгөөр нийт 236.3 сая төгрөгийн зардал хэмнэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг



тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих орлогын 4,527.7 сая төгрөгийн 340 мэдээг, зарлагын 3,851.5 сая төгрөгийн 387 мэдээг, бусад 345 мэдээ нийт 11,107.0 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

ТБОНӨБАУХАТХ-ийг хэрэгжүүлж нээлттэй 9 тендер зарлаж шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан ажилласан боловч Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу Худалдан авалтын төлөвлөгөө, тайланд тусгаагүй 15 гэрээ байгуулж, 31.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь ТБОНӨБАУХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.1-д "Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ."; 49 дүгээр зүйл "Худалдан авах ажиллагааг тайлагнах" 49.2.2-т "Нээлттэй тендер шалгаруулалтаас өөр арга хэрэглэсэн тохиолдолд тухайн аргыг сонгосон үндэслэл"-д заасантай нийцэхгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тайлагнахдаа Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу тайланд бүрэн тусгаж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, худалдан авах ажиллагаа нь төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Шалгагдагч байгууллагатай санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 02 дугаар сарын 01 өдөр YAГ/AA-2023-18 тоот гэрээг байгуулсан тул завсар үеийн аудит хийгдээгүй.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Аудитаар илэрсэн нийт 53.0 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 38.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 15.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн, биелэлт 80.0 хувьтай байна.

## Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Б	1	2	3	4	5	6
1	Албан шаардлага	1	38,494.4	1	24,426.1	70.0
2	Зөвлөмж	3	14,496.1	3	14,496.1	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>52,990.5</b>	<b>4</b>	<b>38,922.2</b>	<b>80.0</b>

Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар 2021 онд “Мандал ирээдүйн өсөлт хамтын хөрөнгө оруулалтын сан” ХХК-тай 450.0 сая төгрөгийн гэрээ байгуулж үйлчилгээ үзүүлсэн боловч гэрээний дагуу төлбөрөө төлөөгүй тул асуудлыг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандсаныг, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд бүртгэлтэй үр тарианы зориулалттай газрын эзэмших эрхийг шилжүүлэх эсэх асуудлуудыг тус тус авч үзэх нь зүйтэй.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 517.3 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 517.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

- Тайлант оны орлогын татварын зардлыг 63.8 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС -12 Орлогын албан татвар стандартын 12-т "Тухайн тайлант болон өмнөх тайлант хугацаанд хамаарах тайлант үеийн татварыг түүний төлөгдөөгүй байгаа дүнгээр өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалт, ААНОАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Энэ хуулийн 13.1, 13.2- т заасан нөхцөл ,хязгаарыг хангаагүй зардал" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.
- Байгууллагын эзэмшлийн газарт 440.4 сая төгрөгийн элэгдэл тооцон тайлагнасан нь НББОУС-16 Үндсэн хөрөнгө " Газар ба барилгыг хамтад нь худалдан авсан байсан ч тусдаа салгаж болох хөрөнгүүдийг тус тусад нь бүртгэж, тайлагнадаг. Хайрга болон хог булах зориулалттай газар гэх мэт зарим гажих нөхцөлөөс бусад тохиолдолд газар нь хязгааргүй ашиглалтын хугацаатай тул элэгдэл тооцдоггүй" гэсэн заалт, ААНОАТ-ын хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан "элэгдэл, хорогдол тооцох хөрөнгийн бүлэг" /бүлгийн жагсаалтад газарт элэгдэл тооцохоор заагдаагүй/ гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.
- Найдваргүй авлагад тооцсон дүнгээс төлөгдсөн 13.2 сая төгрөгийг орлогоор бүртгээгүй нь байгууллагын НБББББ-ийн "Хэрэв найдваргүй гэж үзээд данснаас бүрмөсөн хассан авлага эргэн төлөгдөхөд үйл ажиллагааны бус орлогоор хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцээгүй, ААНОАТ-ын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан нөхцөл, хязгаарыг хангаагүй зардал" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 25.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 15.1 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 9.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 0.3 сая төгрөгийн үйл ажиллагаанд хамааралгүй худалдан авалт хийсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Жилийн санхүүгийн тайлан дахь авлагаас 14 харилцагчийн 7.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцро нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох



бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог, хянах ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тайлант хугацаа бүрийн эцэст харилцагч тус бүрээр авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Шатахууны зарлагыг жолоочийн тооцооны хуудастай тулган шалгахад спидометрийн заалтыг тэмдэглээгүй, хэн, хаашаа, явсан нь тодорхой бус 7.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 -т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах"; Зам тээврийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн журналаас 915.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг Цахим төлбөрийн баримтын системтэй тулган шалгахад 9.7 сая төгрөгийн и баримтын бүрдэл хангаагүй гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4.1.13 "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийсэн цаг тухайд нь НӨАТ-ын баримтад бүртгүүлж сар бүрийн 10-ны дотор бэлтгэн нийлүүлэгчтэй НӨАТ-ын тулгалт хийж бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**2. НБББББ-тэй холбоотой асуудал**

Экспортод гаргах нүүрс болон ашигт малтмалыг биржээр дамжуулан худалдах үйл ажиллагаатай холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого, бичилтийн арга зүйг НБББББ-т нэмж тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-т "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тус компанийн санхүүгийн ажилтнууд нь шинээр нэмэгдсэн үйл ажиллагааны чиглэлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого арга зүйг стандартад нийцүүлэн боловсруулж, НБББББ-т тусгах өөрчлөлтийг нэмэлт зардал гаргахгүйгээр тусгаж, мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант оны орлогын татварын зардлыг 63,797.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	63,797.5			1	63,797.5	1	63,797.5				
2	Байгууллагын эзэмшлийн газарт 440,323.4 мянган төгрөгийн элэгдэл тооцсон.	1	440,323.4			1	440,323.4	1	440,323.4				
3	Найдваргүй авлагад тооцсон дүнгээс төлөгдсөн 13,190.4 мянган төгрөгийг орлогоор бүртгээгүй.	1	13,190.4			1	13,190.4	1	13,190.4				
4	Экспортод гаргах нүүрсийг тайлант онд биржээр дамжуулан худалдах үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг байгууллагын НБББББ-т нэмж тусгаагүй.	1	0.0							1	-	1	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>517,311.3</b>			<b>3</b>	<b>517,311.3</b>	<b>3</b>	<b>517,311.3</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>





6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	14 харилцагчийн 7.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	7,920.4			1	7,920.4						
2	Шатахууны зарлагыг жолоочийн тооцооны хуудастай тулган шалгахад спидометрийн заалтыг тэмдэглээгүй, хэн, хаашаа, явсан нь тодорхой бус 7.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	7,220.1			1	7,220.1						
3	И баримтын бүрдэл хангаагүй 9.7 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.	1	9,706.7					1	9,706.7				
4	Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн шалгахад 0.3 сая төгрөгийн үйл ажиллагаанд хамааралгүй худалдан авалт хийсэн.	1	341.8	1	341.8								
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>25,189.0</b>	<b>1</b>	<b>341.8</b>	<b>2</b>	<b>15,140.5</b>	<b>1</b>	<b>9,706.7</b>				

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Худалдан авалтын төлөвлөгөө, тайланд тусгаагүй 31.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна.	1	31,194.2					1	31,194.2
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>31,194.2</b>					<b>1</b>	<b>31,194.2</b>







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 дугаар сарын 21

№ 139/А0150061

Улаанбаатар хот

СНАГ-2023/49/НБ-ОТД-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь тайлант онд өөрийн үйл ажиллагаанд хамааралгүй 341,809.08 төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6. Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн үйл ажиллагаанд хамааралгүй худалдан авалт хийсэн 341,809.08 (Гурван зуун дөчин нэгэн мянга найман зуун есөн төгрөг найман мөнгө) төгрөгийг, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогыг 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Алтай/, Ерөнхий нягтлан бодогч /С.Алтаннамар/ нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХ-НИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 21 № 521/А0150061

Улаанбаатар хот

СНАГ-2023/49/НА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант жилийн санхүүгийн тайлан дахь авлагаас 14 харилцагчийн 7,902,391.16 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог, хянах ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаа бүрийн эцэст харилцагч тус бүрээр авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Алтай/, Ерөнхий нягтлан бодогч /С.Алтаннамар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХ-КИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 05 дугаар сарын 01 № 520/А0150061

Улаанбаатар хот

СНАГ-2023/49/НА-СТА-ТОА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны зарлагыг жолоочийн тооцооны хуудастай тулган шалгахад спидометрийн заалтыг тэмдэглээгүй, хэн, хаашаа, явсан нь тодорхой бус 7,220,118.13 төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах"; Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Жишиг норм батлах тухай" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хөтөлж, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Х.Алтай/, Ерөнхий нягтлан бодогч /С.Алтаннамар/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХ-КИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.БЯМБАЖАВ

Утас: +976 51 261585  
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг